

**МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ТУХАЙ**

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	Энэ хуулийн зорилт нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Мал, махны үйлвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ: 8.1.1. мал, мах бэлтгэх ажлыг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэх; 8.1.2. мал, мах бэлтгэх, худалдах-худалдан авах гэрээ болон түүний хавсралт, эрүүл ахуй, ариун цэврийн сертификатыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалж байх; 8.1.3. амьдын жингээр авч нядалж, бэлтгэж байгаа малын толгой, арьс, ширийг анхан шатны боловсруулалт хийж, нядалгаа хийснээс хойш 3 хоног хадгалж, эрх бүхий албан тушаалтанд саадгүй үзүүлж байх; 8.1.4. мал, мах бэлтгэх ажлыг энэ хуулийн 5.1.5-д заасан цэгт хийх. 8.2. Тээврийн хэрэгслийн жолооч нь мах бэлтгэлийн зориулалттай мал, махыг тээвэрлэхдээ гарал үүслийн гэрчилгээтэй эсэхийг нь шалгасны үндсэн дээр тээвэрлэнэ